

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 14 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/106/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ч.Мөнхбаяр Утас: 89275858 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	18
4.1 Ерөнхий зүйл.....	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж.....	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 118

танай _____ -ны № _____ -г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Хонгор сумын 14 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан сумын Хонгор сумын 14 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 18,072.6 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, Хонгор сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 14,300.0 мянган төгрөгийн ухаалаг самбар, 959.8 мянган төгрөгийн камер хянах дэлгэц, 4,300.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар 3,225.9 мянган төгрөгийн ном, 2,486.3 мянган төгрөгийн смарт зурагтын тус тус үнэ төлбөргүйгээр хүлээн авч, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, тайлагнасан байна

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 1,353,128.5 мянган төгрөг болж, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 55.3 хувиар өссөн байна.

Бусад асуудал

Дархан Уул аймгийн Дархан сумын Хонгор сумын 14 дүгээр сургуулийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 68 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 100 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр Боловсролын газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР




2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ


2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	243,158,627.52	222,263,434.68
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	134,118,650.87	94,736,059.13
312	Банканд байгаа бэлэн мөнгө	134,118,650.87	94,736,059.13
3121	төгрөг		
31211	Төрийн сангийн харилцах		
33	АВЛАГА	731,634.10	-
332	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-
3351	Байгууллагаас авах авлага	731,634	-
35	БАРАА МАТЕРИАЛ	108,308,342.55	127,527,375.55
351	Түүхий эд материал	363,000.00	78,000.00
3511	Тусгай зориулалттай материал	0.00	0.00
3513	Эм боох материал	363,000.00	78,000.00
354	Хангамжийн материал	107,945,342.55	127,449,375.55
35410	Бичиг хэргийн материал	1,084,700.00	1,715,870.00
35420	Аж ахуйн материал	36,429,410.55	36,786,910.55
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	0.00
35440	Түлш, шатах тослох материал	779,629.20	0.00
3545	Барилгын засварын материал	5,005,650.00	10,672,250.00
3546	Хүнсний материал	3,130,200.00	1,853,130.00
35470	Бусад хангамжийн материал	61,515,752.80	76,421,215.00
36	НӨӨЦ БАРАА		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,746,773,995.15	2,766,859,273.86
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,746,773,995.15	2,766,859,273.86
392	Биет хөрөнгө	2,707,111,995.15	2,727,197,273.86
39201	Барилга, байгууламж орон сууц	2,496,203,240.00	2,616,203,240.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(327,409,278.20)	(393,773,486.03)
39203	Авто тээврийн хэрэгсэл	0.00	0.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.00	0.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	443,737,654.56	499,941,357.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	(182,041,489.09)	(244,141,630.76)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	330,790,867.41	344,382,577.41
39208	Хуримтлагдсан элэгдэл	(105,399,672.57)	(142,957,109.44)
39214	Бусад үндсэн хөрөнгө	37,479,183.87	37,479,183.87
39215	Хуримтлагдсан элэгдэл	(21,114,515.98)	(22,827,499.18)
39217	Ном	34,866,005.15	32,890,640.43
393	Биет бус хөрөнгө	39,662,000.00	39,662,000.00
39301	Программ хангамж	16,182,632.00	16,182,632.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(16,182,632.00)	(16,182,632.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	39,662,000.00	39,662,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,989,932,622.67	2,989,122,708.54



4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,763,400.00	2,054,400.00
413	Өглөг	1,763,400.00	2,054,400.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,763,400.00	2,054,400.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,988,169,222.67	2,987,068,308.54
51	Засгийн газрын хувь оролцоо	2,988,169,222.67	2,987,068,308.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	382,077,381.89	382,077,381.89
51101	Өмч: - төрийн	382,077,381.89	382,077,381.89
512	Хуримтлагдсан үр дүн	273,148,810.34	272,047,896.21
51210	Өмнөх үеийн үр дүн	273,148,810.34	273,148,810.34
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	(1,100,914.13)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,332,943,030.44	2,989,122,708.54
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,989,932,622.67	2,989,122,708.54



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,051,329,584.30	2,225,590,384.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	522,706,584.30	194,388,984.20
120	Нийтлэг татварын бус орлого	522,706,584.30	194,388,984.20
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,105,648.00	35,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	3,225,919.00
120009	Бусад орлого	-	18,953,400.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	350,906,715.50	161,643,923.20
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	169,694,220.80	10,530,742.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,528,623,000.00	2,031,201,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,263,002,600.00	1,667,851,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / төсөвт байгууллага/	1,263,002,600.00	1667851400
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	265,620,400.00	363,350,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/	265,620,400.00	363,350,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,700,999,920.51	2,221,490,014.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,700,999,920.51	2,221,490,014.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,661,592,353.81	2,166,838,728.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	870,891,678.73	1,353,128,518.70
210101	Үндсэн цалин	647,888,979.11	892,969,247.03
210102	Нэмэгдэл	184,242,742.47	413,054,871.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	38,759,957.15	47,104,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,226,953.13	166,204,562.67
210201	Тэтгэврийн даатгал	73,152,428.01	113,476,914.18
210202	Тэтгэмжийн даатгал	9,062,663.58	13,287,738.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,807,810.79	6,685,981.24
210204	Ажилгүйдлийн даатгал	1,695,474.89	6,534,056.18
210205	Эрүүл мэндийн даатгал	16,508,575.86	26,219,872.93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	255,187,823.30	324,439,964.20
210301	Гэрэл, цахилгаан	13,608,142.30	16,004,525.20
210302	Түлш, халаалт	212,227,434.00	283,618,624.00
210303	Цэвэр, бохир ус	29,352,247.00	24,816,815.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,542,730.00	41,530,536.20
210401	Бичиг хэрэг	0.00	9,649,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	37,800.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25,504,930.00	31,881,236.20
2105	Нормативт зардал	58,792,907.20	63,987,518.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	320,000.00
210502	Хоол, хүнс	58,792,907.20	63,667,518.00

7

ХТӨ-5430/9802200


2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,302,500.00	8,733,700.00
210604	Урсгал засвар	1,302,500.00	8,733,700.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	161,803,647.00	21,738,503.97
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	155,395,947.00	553,400.00
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,407,700.00	21,185,103.97
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	179,844,114.45	187,075,425.07
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,614,070.00	18,821,005.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,200,000.00	519,650.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	141,030,044.45	167,734,769.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,407,566.70	54,651,285.80
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,755,290.00	41,998,750.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	38,755,290.00	41,998,750.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	652,276.70	12,652,535.80
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	652,276.70	12,652,535.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	350,329,663.79	4,100,369.59
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	909,110.25	5,201,283.72
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	909,110.25	5,201,283.72
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(909,110.25)	(5,201,283.72)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	349,420,553.54	(1,100,914.13)



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,530,728,648.00	2,050,189,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,105,648.00	18,988,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,105,648.00	18,988,400.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,105,648.00	35,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
120009	бусад орлого		18,953,400.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,528,623,000.00	2,031,201,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,263,002,600.00	1,667,851,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,263,002,600.00	1,667,851,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	265,620,400.00	363,350,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	265,620,400.00	363,350,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,410,965,733.16	2,059,895,681.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,410,965,733.16	2,059,895,681.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,371,345,216.46	2,013,543,154.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	870,997,478.73	1,352,396,884.60
210101	Үндсэн цалин	644,405,327.73	892,237,612.93
210102	Нэмэгдэл	187,540,242.00	413,054,871.67
210104	Урамшуулал	39,051,909.00	47,104,400.00
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,958,587.23	166,204,562.67
210201	Тэтгэврийн даатгалын	73,876,820.11	113,476,914.18
210202	Тэтгэмжийн даатгалын	9,062,663.58	13,287,738.14
210203	ҮОМШӨ-ий даатгалын	7,815,052.79	6,685,981.24
210204	Ажилгүйдлийн даатгалын	1,695,475.44	6,534,056.18
210205	Эрүүл мэндийн даатгалын	16,508,575.31	26,219,872.93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	255,187,823.30	324,439,964.20
210301	Гэрэл, цахилгаан	13,608,142.30	16,004,525.20
210302	Түлш, халаалт	210,133,927.00	283,618,624.00
210303	Цэвэр, бохир ус	31,445,754.00	24,816,815.00
2104	Хангамж, бараа материал	-	-
2105	Нормативт зардал	60,184,957.20	69,760,406.50
210502	Хоол хүнс	60,184,957.20	69,760,406.50
2106	Эд хогшил урсгал засвар	9,780,300.00	26,292,500.00
210604	Урсгал засвар	9,780,300.00	26,292,500.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
210702	Дотоодын томилолт	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	8,128,300.00	21,738,503.97
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,720,600.00	553,400.00
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,407,700.00	21,185,103.97




2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,107,770.00	52,710,332.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,010,380.00	40,982,195.50
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	10,097,390.00	11,728,137.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,620,516.70	46,352,527.30
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,968,240.00	33,699,991.50
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	38,968,240.00	33,699,991.50
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт , шилжүүлэг	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	652,276.70	12,652,535.80
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	652,276.70	12,652,535.80
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	119,762,914.84	(9,705,881.74)
4	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	-	29,676,710.00
0	Дотоод эх үүсвэр	0	29,676,710.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0	29,676,710.00
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	0	(29,676,710.00)
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	119,762,914.84	(39,382,591.74)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,249,936.03	134,118,650.87
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	134,118,650.87	94,736,059.13



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан


Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны НИИТ ДҮН	/төгрөгөөр/
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	382,077,381.89	2,332,943,030.44	(76,271,743.20)	-	2,638,748,669.13	
C02	Няглан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-	
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	382,077,381.89	2,332,943,030.44	(76,271,743.20)	-	2,638,748,669.13	
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-	
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-	
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-	
C07	Тайлант үеийн үр дүн			349,420,553.54		349,420,553.54	
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	382,077,381.89	2,332,943,030.44	273,148,810.34	-	2,988,169,222.67	
D01	Няглан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-	
D02	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	382,077,381.89	2,332,943,030.44	273,148,810.34	-	2,988,169,222.67	
D03	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-	
D04	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-	
D05	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-	
D06	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-	
D07	Тайлант үеийн үр дүн			(1,100,914.13)		(1,100,914.13)	
D08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	382,077,381.89	2,332,943,030.44	272,047,896.21	-	2,987,068,308.54	



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,165,591,800.0	2,058,519,855.9		
21	Урсгал зардлын дүн	2,165,591,800.0	2,058,519,855.9	(107,071,944.1)	95.1%
210	Бараа үйлчилгээний зардал	2,116,638,200.0	2,024,819,864.4	(91,818,335.6)	95.7%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,383,424,200.0	1,352,396,884.6	(31,027,315.4)	97.8%
210101	Үндсэн цалин	930,447,700.0	892,237,612.9	(38,210,087.1)	95.9%
210102	Нэмэгдэл	420,781,400.0	413,054,871.7	(7,726,528.3)	98.2%
210104	Урамшуулал	32,195,100.0	47,104,400.0	14,909,300.0	146.3%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	172,928,000.0	166,204,562.7	(6,723,437.3)	96.1%
210201	Тэтгэврийн даатгал	117,591,000.0	113,476,914.2	(4,114,085.8)	96.5%
210202	Тэтгэмжийн даатгал	13,834,300.0	13,287,738.1	(546,561.9)	96.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,917,100.0	6,685,981.2	(231,118.8)	96.7%
210204	Ажилгүйдлийн даатгал	6,917,100.0	6,534,056.2	(383,043.8)	94.5%
210205	ЭМД-ын хураамж	27,668,500.0	26,219,872.9	(1,448,627.1)	94.8%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	333,350,000.0	324,439,964.2	(8,910,035.8)	97.3%
210301	Гэрэл, цахилгаан	21,479,000.0	16,004,525.2	(5,474,474.8)	74.5%
210302	Түлш, халаалт	283,620,000.0	283,618,624.0	(1,376.0)	100.0%
210303	Цэвэр, бохир ус	28,251,000.0	24,816,815.0	(3,434,185.0)	87.8%
2104	Хангамж, бараа материалын зардал		-	-	-
2105	Нормативт зардал	100,131,800.0	69,760,406.5	(30,371,393.5)	69.7%
210501	Эм	-	-	-	0.0%
210502	Хоол хүнс	100,131,800.0	69,760,406.5	(30,371,393.5)	69.7%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,000,000.0	26,292,500.0	(3,707,500.0)	87.6%
210604	Урсгал засвар	30,000,000.0	26,292,500.0	(3,707,500.0)	87.6%
2107	Томилолт, зочны зардал	-	-	-	-
210702	Дотоод томилолт	-	-	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	26,046,000.0	21,738,504.0	(4,307,496.0)	83.5%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	787,800.0	553,400.0	(234,400.0)	70.2%
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	25,258,200.0	21,185,104.0	(4,073,096.0)	83.9%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,758,200.0	63,987,042.5	(6,771,157.5)	90.4%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	59,232,200.0	52,258,905.5	(6,973,294.5)	88.2%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,526,000.0	11,728,137.0	202,137.0	101.8%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,953,600.0	33,699,991.5	(15,253,608.5)	68.8%
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		-	-	-
213101	Засгийн газрын дотоод урсгал шилжүүлэг				
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,953,600.0	33,699,991.5	(15,253,608.5)	68.8%
213204	ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал				
213205	Төрөөс ирнэдэд олгох тэтгэмж, урамшуулал	48,953,600.0	33,699,991.5	(15,253,608.5)	68.8%
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	-			



2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг				
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох	-	-		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг				
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-		
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг				
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-		
	Дотоод эх үүсвэрээр	-	-		
	Тоног төхөөрөмж				
	Бусад хөрөнгө				
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,165,591,800.0	2,019,137,264.2	146,454,535.80	93.2%
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,667,851,400.0	1,667,851,400.0	-	100.0%
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,667,851,400.0	1,667,851,400.0	-	100.0%
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого			-	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-		-	-
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	363,350,000.0	350,697,464.2	12,652,535.80	96.5%
132001	Орон нутгийн төсвөөс	363,350,000.0	350,697,464.2	12,652,535.80	96.5%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	134,390,400.0	588,400.0	133,802,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	553,400.0	553,400.0	-	100%
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	133,837,000.0	-	133,837,000.00	-
120009	Бусад орлого		35,000.0	(35,000.00)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	134,118,650.9		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	94,736,059.1		
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	
3	Төсвийн байгууллага	1	1	-	
	АЖИЛЛАГСАДЫН ТОО	53	53	-	
	Удирдах ажилтан	1	1	-	
	Гүйцэтгэх ажилтан	37	37	-	
	Үйлчлэх ажилтан	14	14	-	
	Гэрээт	2	2	-	



2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	18,400,000.00	18,400,000.00	-	100%
21	Урсгал зардлын дүн	18,400,000.00	18,400,000.00	-	100%
210	Бараа үйлчилгээний зардал	18,400,000.00	18,400,000.00	-	100%
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-	-	-
210401	Бичиг хэрэг	-	-	-	-
210402	Тээвэр шатахуун	-	-	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	-	-	-	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	-	-	-	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,400,000.00	18,400,000.00	-	100%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,400,000.00	18,400,000.00	-	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-	-	-
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	18,400,000.00	18,400,000.00	-	100%
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,400,000.00	18,400,000.00	-	100%
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,400,000.00	18,400,000.00	-	100%



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 14 дүгээр сургууль нь Хүүхэд бүрийн өөрийгөө илэрхийлэх чадварт ахиц гарган, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоог нэмэгдүүлж, цахим сургалтын орчинг сайжруулах зорилго тавин ажиллаж байна.

Байгууллагын гадаад, дотоод орчин

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 14 дүгээр сургууль Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль Хүүхэд хамгааллын тухай хууль болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын “Аргачлал, зардлын норматив батлах тухай” 2022 оны А/23,27 дугаар тушаал зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай” тогтоол Монгол улсын Засгийн газрын 2024 оны 53 дугаар тогтоолоор
- “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх” тогтоол Монгол улсын Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоолоор
- “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” тогтоол Монгол улсын Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоолоор
- “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох” тогтоол Монгол улсын Засгийн газрын 2024 оны 82 тоот тогтоолоор
- “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш ажилтанд мөнгөн тэтгэмж олгох” журам Монгол улсын Засгийн газрын 2024 оны 104 тоот тогтоолоор
- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамратсан 2024 оны А/85, А/34 тоот “Орон тооны хязгаарын жишиг норматив батлах тухай” тушаал
- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамратсан 2024 оны 115 тоот “Цэцэрлэг, ЕБС-ийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх дүгнэх” тушаал

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан Уул аймгийн Хонгор сумын 14 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд өөрчлөлт ороогүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн програмтай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан Уул аймгийн Дархан сумын 8 дугаар цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, УСНББОУС -ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 809.9 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	134,118.7	94,736.1	(39,382.6)
Авлага	731.6	-	(731.6)
Бараа материал	108,308.3	127,527.4	19,219.0
Үндсэн хөрөнгө	2,746,774.0	2,766,859.3	20,085.3
Нийт хөрөнгө	2,989,932.6	2,989,122.7	(809.9)
Өр төлбөр	1,763.4	2,054.4	291.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,988,169.2	2,987,068.3	(1,100.9)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,989,932.6	2,989,122.7	(809.9)

Тайлант онд 94,736.1 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэйгээр тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 19,219.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөх 125,104.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, Дархан-Уул аймгийн Хонгор сумын ИТХ-ын 2024 оны 15 дүгээр тогтоолоор 3,331.3 мянган төгрөгийн бусад материалыг хандиваар, ДУА-ийн Засаг даргын 2024 оны 01А/524 тоот захирамжаар 7,199.4 мянган төгрөгийн материалыг тус тус данс бүртгэлд бүртгэж, 149,416.7 мянган төгрөгийн зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 20,085.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 29,676.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, ДУА-ийн Засаг даргын 2024 оны 01А/524 тоот захирамжаар 18,072.6 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, Дархан-Уул аймгийн Хонгор сумын ИТХ-ын 2024 оны 19 тоот тогтоолоор 14,300.0 мянган төгрөгийн ухаалаг самбар, 959.8 мянган төгрөгийн камер хянах дэлгэц, 4,300.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, БЕГ-аас 6 нэр төрлийн 3,225.9 мянган төгрөгийн ном, 2,486.3 мянган

төгрөгийн сматр зурагтын тус тус хүлээн авч данс бүртгэлд бүртгэж, Дархан-Уул аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны 23-01-24-02/109 тоот албан шаардлагын дагуу 120,000 мянган төгрөгийн заалны их засварыг капиталжуулж, 167,734.7 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан нь нөлөөлсөн байна.

Тайлант онд 2,054.4 мянган төгрөгийн богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлтэйгээр тайлагнасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,987,068.3 мянган төгрөг болж 1,100.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 1,256,721.3 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Дээд шатны төсвийн захирагч төсвийн саналыг нийт 563,920.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,820,641.8 мянган төгрөгөөр баталсан байна. Монгол улсын Засгийн газрын 2024 оны 128 тоот тогтоолоор нийт албан хаагчдын цалингийн шинэчлэлийг үндэслэн цалингийн зардлыг 443,716.8 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 55,464.80 мянган төгрөг нэмэгдсэн байна

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,802,241.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 363,500.0 мянган төгрөг нийт 2,165,591.8 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 363,500.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 350,697.5 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 12,652.5 мянган төгрөгийг төвлөрүүлж, өмнөх оны үлдэгдлээс 39,965.0 мянган төгрөг, улсын төсвөөс 1,667,857.4 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 1,707,822.4 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 94,736.0 мянган төгрөг байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
	Код	Нэр			Зөрүү	Биелэлт
1	80111	Тогтмол зардал	363,350.00	363,350.00	-	100.00
2	80226	Байр ашиглалттай холбоотой зардал	2,921.30	2,921.30	-	100.00
3	80233	Хүүхэд хамгаалал	2,882.00	2,882.00	-	100.00
4	80312	Сургалт семинарын зардал	1,894.60	1,894.60	-	100.00
5	81605	Эрүүл мэндийг дэмжих зардал	2,811.50	2,811.50	-	100.00
6	81801	Үдийн цай хөтөлбөр	48,953.60	48,953.60	-	100.00

7	81806	Дотуур байр	350,442.80	350,442.80	-	100.00
8	81816	Хүүхдэд ээлтэй орчин	19,006.30	19,006.30	-	100.00
9	81823	Багшийн мэргэжил дээшлүүлэх зардал	8,456.30	8,456.30	-	100.00
10	81834	Боловсролын стандарт	1,326,793.50	1,219,721.50	(107,072.00)	91.93
10	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа хангах	33,027.30	33,027.30	-	100.00
11	81848	Түрээсийн сурах бичиг	787.80	787.80	-	100.00
12	81875	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	4,264.80	4,264.80	-	100.00
		Нийт дүн	2,165,591.80	2,058,519.80	(107,072.00)	95.06

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тайлант онд тус сургууль нь удирдах 1 ажилтан, гүйцэтгэх 37 ажилтан, үйлчлэх 15 ажилтанг гэрээт 2 ажилтан буюу нийт 55 ажилтантайгаар ажиллаж, 210801- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 553.4 мянган төгрөг, 210901-Бараа үйлчилгээний бусад зардалд 69,941.9 мянган төгрөгийг зарцуулж, худалдан авах ажиллагаатай холбоотой 131,001.3 мянган төгрөгийн ажил, үйлчилгээ төлөвлөж худалдан авах ажиллагааг зохион байгуулж нэг оролцогч шалгарсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Дархан-Уул амьгийн Хонгор сумын Засаг даргын 142 тоот захирамжаар 18,400.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт олгосон байна.

Нэмэлт санхүүжилтийн төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайланд онд тус сургуулийн захиралын А/11 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр үнэлгээний хороо байгуулж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нээлттэй тендер шалгаруулалтаар 131,001.3 мянган төгрөгийн 1 нэг хоол, хүнсний худалдан авах төлөвлөгөөг байршуулж, мэдээллийг цаг тухай бүрд нь тайлагнасан.

Тус нээлттэй тендер шалгаруулалтаар “Арцат алтайн уулс” ХХК шалгарч БН-24/02 тоот хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан Уул аймгийн Хонгор сумын 14 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Ч.Мөнхбаяр гүйцэтгэж анхан шатны хяналтыг чанарын менежер Т.Эрдэнэтуяа, захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан Уул аймгийн Хонгор сумын 14 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ЦЭСБ-Аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 09 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,700,999.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 17,009.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Дархан Уул аймгийн Хонгор сумын 14 дүгээр сургуулийн 2024 оны төсвийг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 157 мэдээллээс 3 мэдээллийг хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол,

шуурхай мэдээлдэг байх”, 6.1.1-т “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.1.3-т “дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны системд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах зөвлөмж хүргүүлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу “Ахмадын сан” байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллах журам”-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд илрүүлсэн алдаа, зөрчил гараагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах 758.9 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг 100 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	758.9	1	758.9	100
Нийт дүн	1	758.9	1	758.9	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 29,676.7 мянган төгрөгийн алдаа¹ илрүүлж, аудитын явцад залруулав. Үүнд:

- Тайланд онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 29,676.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний үйл ажиллагааны зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Нягтлан бодох бүртгэлийн зарчим" 5.1.4. "үнэн зөв байх" заалт, УСНББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", санхүүгийн тайлангийн аудитын "Ангилал", "Оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул мөнгөн гүйлгээний тайланд үйл ажиллагааны мөнгөн зарлагыг бууруулж, хөрөнгө оруулалтын мөнгөн зардлыг нэмэгдүүлэн бүртгэж залруулав.

Мөн аудитаар нийт 3,588.0 мянган төгрөгийн зөрчил² илэрсэн тул төсөвт буцаан төвлөрүүлэх 1,272.0 мянган төгрөгийн акт, 2,316.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Илрүүлэлт: Тус сургуулийн багш М.Нармандах, Д.Дорлгорсүрэн нарт ээлжийн амралт бодоходоо 859.5 мянган төгрөгийн цалинг илүү бодож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 16 дугаар зүйлийн 16.5.5-т *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"* гэж заасантай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

5.1.2 Илрүүлэлт: Тус сургууль хүүхдийн хоолны мах нормыг 412.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн олгосон нь Боловсрол шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2020 оны Дугаар А/166,А/559, 222 тоот "Норматив батлах тухай" тушаалын 1-р хавралт *"Цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн хоногийн хоолны илчлэгийн хуваарилалт"*, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 16 дугаар зүйлийн 16.5.5-т *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"* гэж заасантай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

5.2.1.Илрүүлэлт: Тайлант онд байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар "өөрчлөлтгүй" дүгнэлт авсан шалтгаанаар Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын А/141 дүгээр тушаалыг баримтлан сургуулийн захирлын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлж, 2,316.0 мянган төгрөгийн урамшуулал авсан нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 дахь хэсэгт заасантай нийцээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Санхүүгийн тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмж байхгүй.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

Тайлангийн 4.4.1, 4.4.2-т тусгагдсан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Алдааны товч утга		/мянган төгрөгөөр/											
		Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	29,676.7	-	-	-	-	1	29,676.7	-	-	-	-	-	-
1	29,676.7	-	-	-	-	1	29,676.7	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус сургуулийн захирал М.Санжаа нь Дархан-Уул аймгийн БГ-ын даргын А/141 тоот тушаалыг үндэслэн 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлтээр "өөрчлөлтгүй" гэж дүгнэгдсэнд нэг сарын цалин 1.5 дахин нэмэгдүүлэн 2,316.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон.	1	2,316.0			1	2,316.0						
Тус сургуулийн багш М.Нармандах, Д.Дорлгорсүрэн нарт ээлжийн амралт бодоходоо 859.5 мянган төгрөгийн цалинг илүү бодож олгосон	1	859.5	1	859.5								
Тус сургууль хүүхдийн хоолны мах нормыг 412.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн олгосон	1	412.5	1	412.5								
Дүн	3	3,588.0	2	1,272.0	1	2,316.0	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим системд, байгууллагын батлагдсан төсөв мэдээлэлийг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	-					1	-
Тус сургууль нь Ахмад настны тухай хуулийн 14.7 заасан "Төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" заалтыг зөрчиж ахмадын сан байгуулаагүй байна.	1	-					1	-
Дүн	2	-					2	-